

МОНГОЛ УЛСЫН “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-Д
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2018 оны 08 дугаар сарын 31

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд хамаарах Монгол Улсын "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д тусгагдсан зорилт, үйл ажиллагааны 2018 оны эхний хагас жилийн биелэлтэд хийсэн арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хүрэх түвшинтэй нь харьцуулан, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Төлөвлөсөн үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх хугацаанд хийсэн ажлын гүйцэтгэлийг тухайн /2018/ оны хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 2.1.3, 2.1.4 дугаарт тусгагдсан аж үйлдвэр болон эрдэс баялгийн салбарын 4 зорилтын 9 үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу дүгнэсэн ба 2016-2020 он хүртэлх эхний үе шатны зорилтын хэрэгжилт **55.0** хувийн биелэлттэй байна.

Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээголон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангах зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны хэрэгжилт 40%, хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилтын хэрэгжилт 70%, геологийн салбарын хөгжлийг дэмжих зорилтын хэрэгжилт 70%, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт 40 хувийн тус тус биелэлттэй байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР